



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 1700


Улаанбаатар хот

Эмнэлзүйн заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тулай өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн зааврыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилт, тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Дотрын анагаах ухааны мэргэжлийн салбар зөвлөл /Ц.Сарантуяа/-д үүрэг болгосугай.
4. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, мэдээллийг олгох, хүний нөөцийг чадавхижуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд шаардлагатай сургалтыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Нарантуяа/, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Б.Буянтогтох/-т даалгасугай.

САЙД




С.ЭНХБОЛД

141213755

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 11...
сарын 16 өдрийн 4700 дугаар
тушаалын хавсралт

ТУЛАЙ ӨВЧНИЙ ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР



А. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

А.1. Онош: Тулай

А.2.Өвчний код (Олон улсын 10 дугаар ангилал): M10

А.3.Зааврыгхэрэглэгчид

Энэхүү зааврыг тухайн чиглэлээр ажиллаж буй өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн хэрэглэнэ.

А.4.Зааврын зорилго, зорилт

Тулай өвчний оношилгоо, эмчилгээний менежмент, хяналт, урьдчилансэргийлэлтийн талаар нотолгоонд суурилсан заавар, зөвлөмжөөр хангахад чиглэнэ.

А.5.Зааварт ашигласан нэр томьёо, тодорхойлолт

1. **Амьдралын чанар** – гэдэг нь хүний өдөр тутмын үйл ажиллагаанд хэвийн оролцож чадах чадварыг хэлнэ.
2. **Харааны үнэлгээний оноо** – гэдэг нь өвчтөн мэдэрч байгаа өвдөлт болон биеийн ерөнхий байдлаа өөрөө үнэлснийг эмч нэгтгэн дүгнэх арга юм.
3. **Тофус** – гэдэг нь үе орчмын зөөлөн эдэд хуримтлагдсан моноурат натрийн давсны хуримтлал юм.
4. **Зайдсан хурууны шинж** – гэдэг нь үрэвсэж хавдсан хуруунууд, тэдгээрийн арьс нь улайсан, тэмтрэхэд халуун, үйл ажиллагаа нь алдагдсан байдлыг хэлнэ.
5. **Ясны уйланхай** – гэдэг нь ясны эдэд агаар агуулсан хөндий бүтэц үүсэхийг хэлнэ.
6. **Ясны шалбархай/эрози** – гэдэг нь ясны гадаргуугийн бүтэц алдагдаж гэмтэн бүрэн бүтэн байдал алдагдахыг хэлнэ.
7. **Давхарлан хүрээлэх шинж** – гэдэг нь үений хэт авиан шинжилгээгээр харахад үений мөгөөрсний гадаргууд моносодуратын давс хуримтлагдан эхо ойлт ихэссэн давхарга харагдахыг хэлнэ.
8. **Шээсний хүчил ихсэлт** – гэдэг нь сийвэнгийн шээсний хүчлийн хэмжээ 7мг/дл (416мкмоль/л)-ээс ихсэхийг хэлнэ.
9. **Бурса** – гэдэг нь үений орчимд байрлах үеийг хамгаалах үүрэг бүхий цэлцгэр уут юм.

А.6.Тархвар зүйн мэдээлэл

А.6.1.Үндсэн ойлголт

Нийт хүн амын дунд сийвэн дэх шээсний хүчил ихсэлтийн тархалт 4-12 хувь, тулай өвчний тархалт 0.1 хувь байдаг. Янз бүрийн улс үндэстний хүн амын дунд тулайн үений үрэвсэл 1000 эрэгтэйчүүдэд 5-аас 50 тохиолдол, 1000 эмэгтэйчүүдэд 1-

9 тохиолдол тус тус байдаг байна. Жилд 1000 эрэгтэй тутамд 1-3, 1000 эмэгтэй тутамд 1.2 шинэ тохиолдол бүртгэгддэг.

Монгол улсад тулай өвчний тархварзүйн судалгаа хийгдээгүй боловч эрүүл мэндийн статистикийн мэдээлэлээс харахад жил бүр тохиолдлын тоо өссөн буюу 2014 онд 357, 2015 онд 456, 2016 онд 619, 2017 онд 1071, 2018 онд 1343 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Цусанд ШХ ихсэх нь тулайгаар өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн өвчлөлийн харьцаа 2-7:1 байна. Эрэгтэйчүүд 40-50 нас, эмэгтэйчүүд 60 болон түүнээс дээш насандаа тулайгаар илүү өвчилнө. Цэвэршилтийн өмнөх насанд тохиолдох нь ховор байдаг нь эстроген дааврын үйлдэлтэй холбоотой гэдэг нь батлагдсан. Өсвөр болон залуу насанд цочмог тулайгаар өвчлөх нь маш ховор байдаг байна.

Хоёрдогч гиперурекеми нь бөөрний поликистоз, гидронефроз зэрэг олон эмгэг, бөөрний архаг дутагдлын үед шээсний хүчлийн ялгаралт буурсантай холбоотой үүсдэг. Дээрх шалтгааны улмаас анхдагч шээсэнд шээсний хүчлийн концентраци ихэссэнээс холын болон цуглуулах сувганцарт талстууд үүсэн хуримтлагдаж үрэвсэл үүсгэхийн зэрэгцээ микротофус сувганцарт суудаг. Шээсний хүчиллэг нэмэгдэх тутам шээсний хүчлийн талсжилт нэмэгдэж талст ихээр үүсэж бөөрний гэмтэл нэмэгдэн даамжирвал бөөрний дутагдалд хүргэдэг.

Эрэгтэйчүүдэд сийвэнгийн шээсний хүчлийн хэвийн хэмжээ 3.5-7.0мг/дл (208-416мкмоль/л) эмэгтэйчүүдэд 2.6-6.0мг/дл (155-357мкмоль/л) байдаг бөгөөд нас ахих тусам энэ хэмжээ нэмэгддэг.

А.6.2.Өвчний тавилан

Зааврын дагуу эмчилгээг хийвэл тавилан сайтай. Эмчилгээг дутуу хийх, эсвэл хоолны дэглэм баримтлахгүй, эрсдэлт хүчин зүйлийг арилгахгүй бол бөөрний чулуу үүсч, цаашлаад бөөрний дутагдалд хүргэх зэрэг эрсдэлтэй. Түүнчлэн эмчилгээг дутуу эсвэл буруу хийснээс тофус үүсэх, үений үрэвсэл дахих бөгөөд ингэснээр өвчтөний амьдарын чанар муудаж, ажлын бүтээмж буурдаг.


Б. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ (АЛГОРИТМ)

Б.1. Урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг

Тулай өвчин үүсэхэд нөлөөлөхдараах эрсдэлт хүчин зүйлүүдээс зайлсхийнэ. Үүнд:

- Эмийн зохисгүй хэрэглээг хязгаарлах
- Биеийн жинг хэвийн түвшинд барих
- Хоолны дэглэм баримтлах (уургийн агууламж багатай хоол хүнс хэрэглэх, хүнсний ногоо хэрэглэх, өдөрт уух усны хэмжээг нэмэгдүүлэх, архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх)
- Хавсарсан эмгэгтэй тохиолдолд тогтмол хяналтад байж хянах

Б.2. Оношилгооны ерөнхий алгоритм



Алгоритм 1. Тулай өвчний оношилгооны ерөнхий алгоритм.

Б.3. Эмчилгээний ерөнхий алгоритм



Алгоритм 2. Тулай өвчний эмчилгээний алгоритм.

Б.4.Үйлчлүүлэгчийг дараагийн шатны эмчид илгээх шалгуур

Өрх, сум, дүүргийн эрүүл мэндийн төв нь тулай өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хянах, эмийн гаж нөлөө илэрсэн тохиолдолд цаг алдалгүй тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлагатай бөгөөд жилд 2 болон түүнээс дээш удаа тулайн дайрлага илрэх, бусад үений хүндрэл гарсан тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт илгээнэ.

В. ҮЙЛДЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АРГАЧЛАЛ

В.1. ӨВЧНИЙ ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ

Өвчний олон улсын 10-р ангилал

M10	Тулай
M10.0	Шалтгаан тодорхойгүй тулай
M10.1	Хар тугалганы шалтгаант тулай
M10.2	Эмийн шалтгаант тулай
M10.3	Бөөрний үйл ажиллагааны дутмагшлаас улбаалсан тулай
M10.4	Бусад хоёрдогч тулай
M10.9	Тулай тодорхойгүй

В.2. ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС

- Эрэгтэй хүйс
- 40 болон түүнээс дээш нас
- Таргалалт
- Удамшлын өгүүлэмж
- Архины хэрэглээ
- Бөөрний эмгэгшил, бөөрний дутагдал
- Артерийн даралт ихсэх

Сийвэнгийн шээсний хүчил ихсэхэд нөлөөлөх эмгэгүүд:

- Бөөрний уйланхай
- Нефропати
- Чихрийн шижингийн нефропати
- Чихрийн шижингийн кетоацидоз
- Амьсгалын дутагдал
- Архины цочмог хордлого
- Гипер болон гипопаратиреоз
- Архаг хордлого

Шээсний хүчлийг ихэсгэх болон хоёрдогч тулайд нөлөөлөх эмүүд

А. ШХ-ийг хэт нийлэгжүүлэхэд нөлөөтэй эм:

- Этанол
- Фруктоз
- Эс хордуулах эмүүд
- В12 аминдэм
- Варфарин

Б. ШХ-ийн ялгаруулалтыг саатуулахад нөлөөтэй эм

- Этанол
- Шээс хөөх эмүүд
- Салицилат
- Циклоспорин

- Этамбутал
- Пиразинамид
- Леводопа
- Ангиотензины рецептор хориглогч эмүүд
- Вазопрессин
- Гэдэс цэвэрлэх эмүүд
- Никотины хүчил


Тулай өвчин нь бусад өвчинтэй хавсарч болно. Үүнд:

- Гидерлипидеми
- Артерийн гипертензи
- Атеросклероз

В.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ

Тулай өвчин нь бодисын солилцооны алдагдлаас үүсдэг бөгөөд бөөр шээсний замын чулуу үүсгэх, даралт ихсэлт болон бусад зүрх судасны эмгэгийн эрсдэлт хүчин зүйл болдог тул тэдгээрээс сэргийлэхийн тулд эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх шаардлагатай. Мөн зарим эмийн бодисууд сийвэнгийн шээсний хүчлийн хэмжээг нэмэгдүүлдэг тул эмийн зохистой хэрэглээг баримтлах шаардлагатай.

В.4. ЭРТ ИЛРҮҮЛЭГ



Алгоритм 3. Тулай өвчний эрт илрүүлэг

В.5. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

В.5.1.Зовуур, эмнэлзүйн шинж тэмдэг

Тулай өвчний үед эмнэлзүйн дараах хэлбэрүүд тохиолдоно. Үүнд:

- Шинж тэмдэггүй сийвэнгийн шээсний хүчил ихсэлт
- Тулайн дайрлага
- Завсарлагатай тулай, дахилтат тулайн дайрлага
- Тофустай тулай, архаг тулай

Шинж тэмдэггүй сийвэнгийн шээсний хүчил ихсэлт - Сийвэнгийн шээсний хүчлийн хэмжээ 7мг/дл-ээс ихэссэн боловч тулай өвчний шинж тэмдэг илрээгүй эмнэлзүйн байдлыг үений үрэвсэл ба тулайн шинж тэмдэггүй сийвэнгийн шээсний хүчил ихсэлт гэнэ.

Тулайн дайрлага - Ихэвчлэн доод мөчний нэг үеийг хамарч үрэвслийн идэвх өндөртэй, өвдөлт ихтэй байна. Үрэвссэн үе болон хэсгийн ойролцоох зөөлөн эдийн арьс улайсан, халуун, үйл ажиллагаа алдагдаж “зайдсан хурууны шинж” илэрнэ. Өвдөлт эхэлснээс хойш 12-24 цагийн дараа шинж тэмдэг оргилдоо хүрнэ. Хэрвээ эмчилгээ хийгээгүй тохиолдолд хэдэн өдрөөс хэдэн долоо хоног хүртэл хугацаанд үргэлжилж болно.

Завсарлагатай тулай, дахилтат тулайн дайрлага - Тулайн анхны дайрлага өгснөөс хойш намжмал үед шилжсэн өгүүлэмжтэй, тулайн дайрлага дахин гэнэт илэрнэ. Намжмал үеийн хугацаа ямар ч байж болно. Ихэвчлэн эмчилгээ хийлгээгүй тулай өвчинтэй хүмүүс эхний 2 жилд тулайн дайрлаганд дахин өртдөг. Дараагийн тулайн дайрлагын үед шинж тэмдэг хүндэрч үйл ажиллагааны алдагдал нэмэгдсэн, олон үеийг хамарсан байх ба халууралт мөн үүсдэг байна. Энэ үед шагай, тавхайн дээд хэсэг, бугуй, гарын хуруу, тохой зэрэг үеүдийг хамарч болдог. Цөөн тохиолдолд мөр, түнх, эгэм-өвчүүний үений цэлцгэр уутанцарыг хамарч болдог. Нийт тохиолдлын 20-иос бага хувьд олон үеийг хамардаг боловч сүүлийн үед олон үеийг хамрах тохиолдол нь нэмэгдэж байна. Энэ нь эмчилгээ хийлгэлгүй удаан байсан, эмчилгээг дутуу хийлгэсэнээс үүдэлтэй. Олон дахилттай, богино хугацааны эсвэл шинж тэмдэггүй үетэй, тэмтрэлтээр тофус тодорхойлогдох нь элбэг. Нуруу болон ууц сүүжний үеийг маш цөөн тохиолдолд хамарч болдог.

Тофустай тулай, архаг тулай - Шээсний хүчил хэлбэржиж зөөлөн эдэд хуримтлагдсанаар тофус үүсдэг. Ихэвчлэн чих, зөөлөн эд, үений бүтэц, шөрмөс, болон бурсанд тэмтрэгдэх ба улайлтгүй болон эмзэглэлгүй байдаг. Арьсан доороос овойсон, шар эсвэл цагаан өнгөтэй харагдана. Архаг, удаан хугацааны үрэвслийн улмаас хуруун дээр тофус үүсдэг энэ нь хурууны үрэвсэл болон бусад өвчний шинж тэмдэгтэй андуурагдах магадлалтай тул анхаарах хэрэгтэй.

В.5.2. БОДИТ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ

В.5.2.1.Дурдатгал (анамнез)

Тулайн дайрлагын үед эмнэлзүйн шинж тэмдэг тод байх бөгөөд үүнд:

- Ихэвчлэн хөлийн эрхий хурууны үеэр өвдөж эхлэх
- Өвдсөн үе юманд хүрж болохгүй маш их өвдөлттэй байх
- Өвдсөн талын хөл гишгэхэд эмзэглэл ихтэй байх
- Үений өвдөлт 24 цагийн дотор хамгийн дээд цэгтээ хүрсэн байх
- Өвдсөн үений арьс улайсан, хавдсан байх
- Бусад бодисын солилцооны эмгэг болон даралт ихсэлт, дислипидеми, зүрх судасны бусад эмгэг болон амьдралын хэв маягийн талаар дэлгэрэнгүй асууж тодруулна.

В.5.2.2. Бодит үзлэг

Бодит үзлэгээр үрэвссэн үе болон үений ойролцоох хэсгийн арьс улайсан, хавдсан, халуун, эмзэглэл ихтэй байна.

В.5.2.3. Эрэмбэлэн ангилал, яаралтай тусламж үзүүлэх шалгуур

Тулай оноштой хүмүүст дараах тохиолдлуудад үйлчилгээний харьяалал харгалзахгүй хамгийн ойролцоох эмнэлэг яаралтай тусламж үйлчилгээ үзүүлнэ.

- Хоёрдогч халдварын хүндрэл
- Уратын эсвэл шээсний хүчлийн нефропати
- Бөөрний чулууны шалтгаант БШДЗ-ын бөглөрөл, халдвар, бөөрний дутагдал
- Тулайн тофус бүхий үе мөчний хугарал
- Хүнд хэлбэрийн үрэвсэлт миопати эсвэл үений үрэвсэл
- Зүрхний шигдээс
- Тархины цус харвалт

В.5.2.4. Лабораторийн шинжилгээ

Тулай өвчнийг сэжиглэж буй тохиолдолд онош тодруулах зорилгоор хүснэгт 1-д үзүүлсэн үрэвслийн идэвхижил болон бодисын солилцооны алдагдлыг үнэлэх лабораторийн шинжилгээг хийнэ.

Тулай өвчнөөр өвдсөн хүн бүрт хавсарсан өвчлөл болон зүрх судасны өвчний эрсдэлүүдийг илрүүлнэ. Үүнд бөөрний дутагдал, зүрхний цус хомсрох өвчин, зүрхний дутагдал, харвалт, захын судасны хатуурал, таргалалт, артерийн даралт ихсэх өвчин, чихрийн шижин зэрэг орох бөгөөд эдгээр өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчлэх нь тулай өвчний эмчилгээний чухал хэсэгт багтана.

Хүснэгт 1-д тулай өвчний үед оношилгоонд хэрэглэгдэх лабораторийн шинжилгээ болон илэрч болох өөрчлөлтүүдийг харуулав.

Хүснэгт 1. Оношилгоонд шаардлагатай лабораторийн шинжилгээ, илэрч болох өөрчлөлт

Үзүүлэлт	Лавлах хэмжээ	Өөрчлөлт	Хяналт
Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (ЦДШ)		Нейтрофил давамгайлсан лейкоцитоз	Халдварын шалтгаантай лейкоцитоз болон нетрофилёзоос ялгах хэрэгтэй.
Сийвэнгийн шээсний хүчлийн хэмжээ (ШХ)	Эрэгтэйд: 3.5-7.0мг/дл (208-416мкмоль/л) Эмэгтэйд: 2.6-6.0мг/дл (155-357мкмоль/л)	Ихэснэ	Тулайн дайрлагын үед цитокины нөлөөгөөр буурах тохиолдол байдаг тул анхаарах хэрэгтэй.
Нийт холестерол (НХ)	5.2ммоль/л хүртэл	Ихсэж болно	
Баганягттай липопротеид (БНЛП)	2.6ммоль/л хүртэл	Ихсэж болно	
Триглицерид (ТГ)	1.7ммоль/л хүртэл	Ихсэж болно	
Их нягттай	1.0-1.6ммоль/л	Ихсэж болно	

липопротейд (ИНЛП)			
Ц урвалжит уураг (ЦУУ)		Ихэснэ	Үрэвслийн идэвх өндөр байгаа тохиолдолд ихэснэ

В.5.2.5. Багажийншинжилгээ

- Рентген оношилгоо
- Үений хэт авиан оношилгоо
- Цөмийн оношзүйн оношилгоо
- Компьютер томографи (КТГ)
- Үений соронзон резонанст томографи /СРТГ/

Тулай өвчний үед үений рентген, үений хэт авиа, үений соронзон резонанст томографи шинжилгээг ашиглана.

Үений рентген оношилгоо:

- Онош тодруулах, онош батлах зорилгоор хийнэ.

Өвчний эрт үед хийхийг зөвлөхгүй. Бусад өвчнөөс ялган оношлох, архаг тулайн өөрчлөлтийг илрүүлэх зорилгоор хийнэ. Ясны гадаргууд тофус тодорхойлогдох, тофус үений мөгөөрсөн дээр байрлан сууснаас ясны шалбархай үүсэх ба хожуу үед үе хоорондын зай нарийсах шинж илэрнэ. Уратын артропатийн үед мөгөөрсний доорх ясны шалбархай, ясны ургалт, ясны уйланхай илэрнэ.




Зураг 1. Хөлийн шивнүүрийн эгц байрлалын рентген зураг. Зөөлөн эдийн хаван болон тофус, ясны уйланхай илэрсэн байдал.


Үений хэт авиан шинжилгээ (ҮХАШ):

- Онош тодруулах, онош батлах
- Өвчний явцыг хянах
- Эмчилгээний үр дүнг хянах зорилгоор хийнэ.

Үений мөгөөрсөн дээр эхо ойлт ихэссэн шугаман бүтэц илрэхийг “давхарлан хүрээлэх шинж” гэх ба оношилгооны ач холбогдолтой шинж юм. Мөн үе эсвэл шөрмөсөнд тофус хуримтлагдсан байдал харагдаж болно. (эхо ойлт багассан бүсээр хүрээлэгдсэн эхо ойлт ихэссэн бүс харагдах нь тофусын шинж юм). Хэт авиан шинжилгээний эхо ойлт ихэссэн үүлэрхэг бүс илрэхэд мэдрэг чанар 79% өвөрмөц чанар 95% гэж тооцно. “Давхарлан хүрээлэх шинж”-ийн мэдрэг чанар 44% өвөрмөц чанар 99%, гэхдээ энэ шинж нь хуурамч тулай буюу кальци-пирофосфатын өвчний үед илэрч болдог.



Зураг 2. Дунд чөмөгний толгой хэсгийн ҮХАШ, тууш зүслэг. А. Өөрчлөлтгүй. В. Давхарлан хүрээлэх шинж.




Зураг 3. 1. Өлмий яс ба шивнүүрүүдийн хоорондох үе, 2.Шивнүүрийн үе, жижиг сумаар шивнүүрийн үений зөөлөн эдэд тофус үүссэн, том сумаар хумсны хэвтшинд хуримтлагдсан хатуу тофус, хөндлөн сумаар үүлэрхэг бүсийг харуулсан байна.

Компьютер томографи (КТ):

Өвөрмөц бус байрлалтай тофусыг илрүүлэх ач холбогдолтой. Шээсний хүчлийн хуримтлалыг эрт үед нь үе болон үе орчимд байрласныг илрүүлэх ба кальцийн хуримтлалаас ялган үнэлэх боломжтой.

Үений шингэнд моноурат натрийн давсыг(МУНД) илрүүлэх:

Эхо хяналтан доор (хатгалтын талбайг зөв сонгоход тустай) эсвэл шууд хатгалтаар үений шингэнээс дээж авч электрон микроскопоор шинжилнэ. Кальцийн пирофосфатын өвчин болон тулай өвчнийг оношлох, ялган оношлох маш чухал ач холбогдолтой. Үений шингэн өсгөвөрлөх шинжилгээ хийснээр үжилт артритаас ялган оношилох ач холбогдолтой.



Зураг 4.Моноурат натрийн давс электрон микроскопоор харагдах байдал.

В.5.2.6. Оношилгооны шалгуур ба оношийн баталгаа

Тулай өвчний эрт оношилгоо нь өвчтөний амьдралын чанарыг хадгалж, сайжруулдаг.

Хүснэгт 2. Тулайн оношилгооны шалгуур (АРК- РЭЕХ, 2015 он)

	Эхний шалгуур (зөвхөн энэ шалгуурыг хангасан тохиолдолд доорхи шалгуурлуу орно)	Захын үе болон бурсанаас нэг ба түүнээс олон тооны хавдалт, өвдөлт, эсвэл улайлт илрэх	Тийм Үгүй
	Хангалттай шалгуур (хэрэв энэ шалгуурыг хангаж байгаа тохиолдолд доорхи шалгуурыг ашиглахгүйгээр тулай гэсэн онош тавьж болно)	Шинж тэмдэг бүхий үенд эсвэл бурсанд, тофусанд моносодиумуратын талст илрэх	Тийм Үгүй
	Шалгуур (хангалттай гэж үзэх шалгуурыг хангаагүй тохиолдолд ашиглана) Тулай гэж ангилахад 8 ба түүнээс дээш оноо авах шаардлагатай	Ангилал	Оноо
Эмнэлзүйн	Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд үе болон бурсаны аль хэсгийг хамарснаас хамааран:	-Шагайнаас бусад хэсэгт үе эсвэл бурса, нэгдүгээр МТР үе, тавхайн дунд хэсэг (эсвэл олон үений үрэвсэл илэрсэн тохиолдолд эдгээр үений нэгд илрэх) -Шагайн эсвэл тавхайн дунд хэсэг (нэгдүгээр МТР үе үрэвсээгүй нэг үений болон олон үений үрэвсэлтэй үед) -Нэгдүгээр МТР үе (нэг үений болон олон үений үрэвсэлтэй үед)	0 1 2
	Шинж тэмдэг* бүхий хэсгийн онцлог шинж:	Онцлог шинжгүй	0
	1. Нөлөөлөлд өртсөн хэсэг улайсан байх (өвчтөн өөрөө хэлэх эсвэл эмч үзэж илрүүлэх)	1 онцлог шинж бүхий	1
	2. Нөлөөлөлд өртсөн хэсэгт хүрэх эсвэл даралт үзүүлэх боломжгүй өвчтэй байх	2 онцлог шинж бүхий	2
	3. Нөлөөлөлд өртсөн хэсэг үйл ажиллагаанд оролцож чадахгүй эсвэл алхахад маш хэцүү байх	3 онцлог шинж бүхий	3
	Тохиолдлын үргэлжлэх хугацаа: Дараахаас 2-с дээш шинж илэрсэн байх. (ҮЭДБЭ-ээс шалтгаалахгүй) Үүнд:	Биеийн аль ч хэсэгт өвдөлт байхгүй байх	0
	Биеийн нэг хэсэгт	1	

	<p>1. Хамгийн их өвдөлт 24 цагаас богино үргэлжлэх</p> <p>2. Шинж тэмдэг 14 хоногийн дотор арилах</p> <p>3. Шинж тэмдэг бүхий тохиолдлуудын хооронд бүрэн намжих (суурь түвшинд хүртэл)</p>	Биеийн олон хэсэгт	2
	<p>Тофусын эмнэлзүйн шинж: Арьсан доорхуурай эсвэл шохой шиг зангилаа байх ба судасжилттай байх тохиолдол байдаг. Ихэвчлэн үе, чих, олекранон, бурса, хурууны өндөг, шөрмөс (жишээ нь: ахиллесын) зэрэгт байрладаг.</p>	Илрээгүй	0
		Илэрсэн	4
	<p>Сийвэн дахь шээсний хүчил: Уриказын аргаар хэмжинэ. Хамгийн тохиромжтой оноог өгөхийн тулд өвчтөн шээсний хүчил бууруулах эмчилгээ хэрэглээгүй байх ба шинж тэмдэг илэрснээс хойш 4 долоо хоногийн хугацаанд (завсрын үед) үзнэ. Хэрвээ дээрхи нөхцөл илэрсэн тохиолдолд дахин шинжилнэ.</p>	<4 мг/дл [<0.24 ммоль/л] [†]	-4 0
		4-<6 мг/дл [0.24-<0.36 ммоль/л]	
		6-<8 мг/дл [0.36-<0.48 ммоль/л]	2 3
		8-<10 мг/дл [0.48-<0.60 ммоль/л] ≥10 мг/дл [≥0.60 ммоль/л]	4
	<p>Шинж тэмдэг бүхий үе болон бурсаны үений шингэний шинжилгээ** Сургалтанд хамрагдсан лаборант үнэлнэ.</p>	Хийгдээгүй	0
		Моносодуратын давс илрээгүй	-2
ДО	<p>Дүрс оношилгооны шинжилгээгээр шинж тэмдэг бүхий үе болон бурсад шээсний хүчлийн хуримтлал илрэх: Хэт авиан шинжилгээгээр давхар хүрээний шинж[†] илрэх эсвэл DECT шинжилгээгээр шээсний хүчлийн хуримтлал илрэх[§].</p>	Илрээгүй эсвэл хийгдээгүй	0 4
		Илэрсэн (аль ч шинжилгээгээр)	
	<p>Тулайгаас шалтгаалсан үений гэмтлийн дүрс оношилгооны шинжилгээний өөрчлөлт: Гарын болон хөлийн ердийн рентген зурагт дор хаяж нэг шалбархай^{††} байх.</p>	Илрээгүй эсвэл хийгдээгүй	0 4
		Илэрсэн (аль ч шинжилгээгээр)	
Нийт оноо			
Тулай гэж ангилж болох уу? (хангалттай шалгуурт хүрсэн эсвэл нийт оноо 8-аас их тохиолдолд)			Тийм Үгүй

Хүснэгтэнд ашигласан тэмдэгтүүдийг дараахаар тайлбарлав:

*Шинж тэмдэг бүхий хэсэг гэдэг нь хавдалт, өвдөлт улайлт бүхий захын үе эсвэл бурса юм.

† Хэрэв сийвэнгийн шээсний хүчлийн хэмжээ <4 мг/дл (0.24 ммоль/л) бол 4 оноо хасна, хэрвээ ≥ 4-6 мг/дл (0.24-0.36 ммоль/л) бол 0 оноо өгнө.

** Хэрвээ бэлтгэгдсэн лаборант шинж тэмдэг бүхий үе эсвэл бурсанаас авсан шингэнийг туйлшруулагч микроскопоор харан моноурат натрийн давс илрүүлээгүй тохиолдолд 2 оноо хасна. Хэрвээ үений шингэнд үнэлгээ хийгээгүй (шинжилгээ аваагүй) бол 0 оноо өгнө.

‡ Хэрвээ дүрс оношилгооны шинжилгээ хийх боломжгүй бол 0 оноо өгнө.

¶ Гиалин мөгөөрсний гадаргуу дээрх эхо ойлт ихтэй хэвийн бус бүтэц нь хэт авиан бүртгэгчийн өнцгийг буруу тааруулснаас үүссэн байж болно. (тэмдэглэл: хуурамч эерэг, артефакт)

§ Үе болон үе орчмоос өнгөөр кодолсон шээсний хүчил илрүүлнэ. Зургийг DECT-p 80 ба 140kВэрчмээр авах ба тулайд өвөрмөц программаар өнгөт код бүхий шээсний хүчил байгаа эсэхийг тодорхойлдог. Өнгөт код бүхий шээсний хүчил ихэвчлэн үе болон үе орчимд тодорхойлогддог. Хумсны хэвтэш, арьс, хатуурсан хэсэг, судасны артефакт, хөдөлгөөн зэрэг тодорхойлогдож болох ба эдгээрийг шээсний хүчилтэй андуурахгүй байх хэрэгтэй.


‡‡ Шалбархай нь ясны гадаргуугийн бүтэц эвдэрч, ирмэг нь хатуурч хурц өнцөгтэй болсноор илэрхийлэгдэнэ. DIP үе ба цахлайн далавчний шинжийг тооцохгүй.

Хүснэгт 3. Тулайн оношилгооны шалгуур (Америкийн Ревматологийн Коллеж, 1977 он)

A	Үений шингэнд шээсний хүчлийн давс илрэх
B	Тофус дахь талстыг химийн эсвэл микроскопийн шинжилгээгээр батлах
C	Доорхи 12 шинжээс 6 болон түүнээс олон шинж байх
1	Өгүүлэмжиндээ нэг ба түүнээс олон удаа тулайн дайрлагад өртсөн байх
2	Үений үрэвсэл нь өвчний эхний өдөртөө дээд хэмжээндээ хүрсэн байх
3	Нэг үений үрэвсэл байх
4	Үрэвссэн үений арьс улайх
5	Хөлийн эрхий хурууны нэгдүгээр шивнүүр үеэр өвдөх хавдах
6	Хөлийн эрхий хурууны нэгдүгээр шивнүүр үе нэг талдаа үрэвссэн байх
7	Хөлийн шагай нэг талдаа хавдах
8	Тофус байх магадлалтай
9	Цусанд шээсний хүчил ихсэх
10	Рентгенд хөлийн 2 талд ижил бус хавдалт байх
11	Рентгенээр ясны идэгдэлт байхгүй мөгөөрсөн доорхи уйланхай байх
12	Үений шингэний шинжилгээнд нян илрэхгүй байх
Оношийн баталгаа: А болон В баталгаа дангаараа илрэх эсвэл С баталгаанаас 6 болон түүнээс дээш шинж илрэх.	


Тулай өвчнийг оношилгоонд 1977 онд АРК болон РЭХХамтран гаргасан 2015 оны шалгуурыг ашиглана. Манай орны нөхцөлд 1977 онд батлагдсан АРК-оос гаргасан шалгуур нь эмнэлзүйн практикт ашиглахад тохиромжтой байна.

Тулайн дайрлагын үеийн оношилгооны Алгоритм (алгоритм)



"Эмнэлзүйн оношилгооны дүрэм"-ийг ашиглан доорх үзүүлэлт тус бүрээр үнэлж оноогоор үнэлнэ үү.

- Эрэгтэй хүйс - 2 оноо
- Өмнө нь тулайн дайрлаганд өртөж байсан - 2 оноо
- Эхлэл нь нэг өдөрт цочмоогоор эхэлсэн - 0.5 оноо
- Үе улайсан байх - 1 оноо
- Хөлийн эрхий хурууны том үеийг хамарсан – 2.5 оноо
- Даралт ихсэлттэй эсвэл дор хаяж нэг зүрх судасны эмгэгтэй – 1.5 оноо
- Сийвэнгийн шээсний хүчлийн түвшин 5.88 мг/дл-ээс их – 3.5 оноо



Алгоритм 4. Тулайн дайрлагын үеийн оношилгооны алгоритм

В.5.2.7.Ялган оношилгоо

Хүснэгт 4.Тулайн артритын ялган оношилгоо

Өвчин	Ижил төстэй шинж	Ялгаатай шинж
Үжлийн артрит	Гэнэтийн эхлэлтэй, нэг үеийг хамардаг, үеэр хавдах, улайх, халуурах шинжүүд илэрнэ	ҮЭДБЭ үр дүнгүй, антибиотик эмчилгээнд үр дүнтэй, хоол дэглэмт алдагдалтай холбоогүй
Хайрст үлдийн артрит	Залуу насны хүнд илэрнэ. Хөлийн эрхий хурууны үе хавдана, цэнхэр хөхөлбөр өнгөтэй болно	Сэдрэл богино хугацаанд үргэлжилнэ. Хурдан хэвийн байдалд орно
Урвалт артрит	Тавхай болон нэг үеийг хамарсан артрит. Зөөлөн эдийн хаван, арьс цэнхэр хөхөлбөр өнгөтэй болно.	ҮЭДБЭ ээс илүү үенд ҮЭДБ тарих нь үр дүнтэй.
Ревматоид артрит	Архаг тулай удаан явцтай, давтамжит сэдрэлтэй. 2 талд ижил хэмт артрит хэлбэрээр илэрч болно. Тохой орчим байрласан тофус бурсит үүсгэн ревматоид зангилаатай андуурагддаг.	Олон үений бүтэц эвдрэл, олон эрхтэнг хамарсан байдал. Шинжилгээнд РФ, anti CCP эерэг гарна.
Пирофосф атын артропати	Дахилтат явцтай, хурц артритын сэдрэлээр илэрч болно. Олигортрит хэлбэрээр жижиг үеийг хамарч болно.	75-аас дээш насны эмэгтэйчүүд голдуу илэрдэг. Олон үений яс үений үрэвсэл хэлбэрээр өвдөгний үеийг ихэвчлэн хамардаг. Үений шингэнд пирофосфатын кальцийн талстууд илэрнэ.

В.5.3. ЭМЧИЛГЭЭ

Тулай өвчний үеийн эмчилгээний гол зорилго нь тулайн дайрлагын үед өвдөлт болон үрэвслийг намдаах, цусан дахь шээсний хүчлийн хэмжээг бууруулснаар үеийг гэмтэхээс сэргийлэх, үе болон бусад эдүүдэд тофус үүсэхээс сэргийлэн идэвхитэй үйл ажиллагааны болон амьдралын чанарыг сайжруулахад оршино.

Эрт оношилж эрт эмчлэх нь үений үйл ажиллагааны алдагдал болон хөдөлмөрийн чадвар алдахаас сэргийлдэг.

В.5.3.1. ЭМИЙН БУС ЭМЧИЛГЭЭ

Хоол эмчилгээ

Хориглох хоол хүнс:

- Дотор мах
- Ангийн мах
- Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (хиам, зайдас, гахайн мах гэх мэт)
- Лаазалсан бүтээгдэхүүн
- Их мах чанасан шөл
- Толгой шийр, цэлцэгнүүр
- Архи согтууруулах ундаа (шар айраг, архи, виски, вино, айраг)
- Сахар орлуулагчтай ундаа
- Эрдэнэшишийн уусмал агуулсан амттан

Хязгаартай хэрэглэх хоол хүнс:

- Үхрийн өөхтэй мах
- Хонины өөхтэй мах
- Гахайн мах
- Далайн гаралтай хоол хүнс (далайн байцаа, далайн замаг, сам хорхой гэх мэт.)
- Жимсний шүүс
- Сахар агуулсан ундаа

Хэрэглэж болох хоол хүнс:

- Хүнсний ногоо (ялангуяа ногоон навчит ургамал үүнд:
 - Ногоон навчит ургамал. Үүнд: юуцай, бууцай, жууцай, байцай, шинцай гэх мэт)
- Жимс, жимсгэнэ
- Өөх багатай үхрийн мах
- Загасны мах (туна болон салмон загас)
- Тахианы цээж мах (гуя болон далавч зэргийг хэрэглэх тохиолдолд гаднах хальсыг хэрэглэхгүй)
- Өдөрт уух усны хэмжээг нэмэгдүүлэх (шүлтлэг ус хэрэглэх)

Сэтгэл засал эмчилгээ

Өвчтөнд тулгамдаж байгаа асуудлыг сайтар сонсох замаар сэтгэл засал эмчилгээ хийнэ. Сэтгэл гутрал илэрвэл бүлгийн болон ганцаарчилсан сэтгэл засал эмчилгээ хийнэ.

Мэс засал эмчилгээ

Үрэвсэл намжмал байгаа үед мэс заслын аргаар тофус авах.

Сэргээн засах эмчилгээ

Тулайн дайрлагын үед өвдөлт намдаах зорилгоор хүйтэн жин тавина.

Хөлийн хуруу, шагайг хамарсан тохиолдолд сул оймс өмсөх, хөлөө дээш нь сойх гэх мэт гэрийн нөхцөлд авч хэрэгжүүлэх боломжтой зүйлсийг зөвлөнө.

В.5.3.2. ЭМИЙН ЭМЧИЛГЭЭ

Тулай өвчний эмчилгээний үндсэн хэсэг нь эмийн эмчилгээ юм.

Тулайн дайрлагын үед хэрэглэх эм

1. Үрэвслийн эсрэг дааврын бус эм (ҮЭДБЭ)
2. Үрэвслийн эсрэг дааврын эм (ҮЭДЭ)
3. Колхицин

Шээсний хүчил бууруулах эмчилгээнд хэрэглэх эм

1. Ксантиноксидазын ингибитор
2. Урикозурик эмүүд

В.5.3.2.1. Тулайн дайрлагын үеийн эмчилгээ

Үрэвслийн эсрэг дааврын бус эм (ҮЭДБЭ)

Тухайн өвчтөний амьдралын хэв маяг, хавсарсан өвчин, эмийн гаж нөлөөг тооцон хувь хүний онцлог, тохируулан эмийг сонгоно.

Хүснэгт 5. Үрэвслийн эсрэг дааврын бус эм

Эмийн нэр	Нэг удаагийн тун	Хэрэглэх давтамж
Нафроксен	500 мг	Өдөрт 2 удаа
Индометацин	50 мг	Өдөрт 3 удаа
Ибупрофен	800 мг	Өдөрт 3 удаа
Диклофенак натри	50 мг	Өдөрт 2 удаа
Мелоксикам	15 мг	Өдөрт 1 удаа
Целекоксиб	200 мг	Өдөрт 2 удаа
Локсопрофен	60 мг	Өдөрт 1-2 удаа

Тулайн дайрлагын бүх шинж тэмдэг арилснаас хойш 2-3 хоног үргэлжлүүлнэ.

Хүснэгт 6. Үрэвслийн эсрэг дааврын бус эмийн гаж нөлөө

Гаж нөлөө	Давтамж, %	Тайлбар
<i>Хоол боловсруулах зам</i>		
Биж хам шинж (дотор муухайрах, бөөлжис хүрэх, аюулхай орчим өвдөх)	10-30	Эхний саруудад эмчилгээ зогсоох гол шалтгаан (8-10%). Ходооны дурангийн өөрчлөлттэй хамаарал илрэхгүй
Хоол боловсруулах дээд замын шинж тэмдэггүй шарх болон улайлт	10-50	Ходоодны антрум хэсэгт илэрнэ
Цус алдалт, цооролт,	Жилд 0.5-4 хүн	Эрсдэлт хүчин зүйлээс хамаарна
Нарийн бүдүүн гэдэсний өөрчлөлт	1-5	Төмөр дутлын цус багадалтын үндсэн шалтгаан (целекоксибхэрэглэхэд ховортохиолдоно)
<i>Элэгний өөрчлөлт</i>		
Шинж тэмдэггүй АЛАТ, АСАТ, ШФ ихсэх	1-5	Шалтгаан тодорхойгүй
Эмийн шалтгаант цочмог гепатит	0.01-0.05	Ховор тохиолдоно, амь насанд аюултай
Улаан хоолойн өөрчлөлт (улайлт, шарх, цус алдалт)	<1	Ходоод улаан хоолойн сөргөө өвчний үед илэрнэ
<i>Бөөр шээсний зам</i>		
Түүдгэнцэрийн шүүлтийн	1-5	Бүх ҮЭДБЭ өндөр тунгаар хэрэглэх үед

хурд өөрчлөгдөх		илэрнэ
АД ихсэх	1-10	
Бөөрний хөхлөгийн некроз	<1	
Интерстициаль нефрит	<1	
<i>Зүрх судасны тогтолцоо</i>		
Бүлэн үүсэх Зүрхний дутагдлын декомпенсаци Ацетилсалицилын хүчлийн антиагрегант үйлдэл буурах	1-5	Бүх ҮЭДБЭ өндөр тунгаар болон удаан хугацаагаар хэрэглэх үед ибупрофен
Мэдрэлийн	1-5	Индометацин, ибупрофен, кетлпрофен, флурбипрофен, напроксен
Толгойн өвдөлт	<1	
Асептик менингит	<0.01	
Арьсны тууралт, загатнаа	<1	Мелоксикам хэрэглэхэд ховор тохиолдоно
Цусны Агранулоцитоз	<1	Фенилбутазон, ховор тохиолдолд индометацин
Уушгины багтраа, пневмонит	<1	Ацетилсалицилийн хүчил
Бусад Чихэнд үзүүлэх сөрөг нөлөө	<1	Ацетилсалицилийн хүчил өндөр тунгаар хэрэглэх үед илэрч болно
Үргүйдэл	<1	
Стоматит, сиаладенит, панкреатит	<1	Фенилбутазон
сульфонамидын харшил	<1	Целекоксид эсрэг заалттай
